



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 22 өдөр

Дугаар A/54

Сүхбаатар сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "е", "л", 30 дугаар зүйлийн 30.1.17, аймгийн Засаг дарга Үндэсний хөгжлийн газрын даргатай байгуулсан "2021 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр хамтран ажиллах гэрээ"-ний 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн үйлдвэрлэлийн нэгдсэн тооллогыг зохион байгуулах, дүн мэдээллийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санд оруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

А.Эрдэнэгэрэл

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Я.Мөрөн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

Б.Мөнхтөр

-Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Б.Саранчимэг

-Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Б.Саруултөгс

-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Д.Гүндэгмаа

-Статистикийн хэлтсийн дарга

П.Эрдэнэсайхан

-Орон нутгийн өмчийн газрын дарга
-Сумдын Засаг дарга

C:\users\albanbichig2021\zahiramjA4.docx

430800073

2. Үйлдвэрлэлийн тооллогыг аймаг, орон нутагт шуурхай зохион байгуулж, холбогдох мэдээллийг нэгдсэн санд оруулан баталгаажуулахыг Ажлын хэсгийн ахлагч Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /А.Эрдэнэгэрэл/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ